



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/053/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn Аудитор: Л.Одонтуяа Утас: 325093 Цахим хаяг: Odontuyal@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025. 03. 14 № 01/311
танай _____ -ны № _____ -т

**НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.ОДБАЯР ТАНАА**

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 125,047,825.3 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх", "Үнэн зөв байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төрийн аудитын байгууллагад 2024 оны санхүүгийн тайлантай холбоотой мэдээ, мэдээлэл, холбогдох баримтыг цаг хугацаанд нь үнэн зөв ирүүлээгүйгээс аудит хийхэд хүндрэл үүсгэж, цаг хугацааны хязгаарлагдмал байдал үүсгэсэн.

Аудитын гол асуудал

Төрийн аудитын байгууллагад өмнөх оны хариуцлага тооцох албан шаардлагын биелэлтийг нотлох баримтыг хуурамчаар гаргаж ирүүлсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг эрх бүхий байгууллага 93.9 хувиар хэрэгжсэн гэж үнэлсэн байна.

Нийслэлийн Засаг даргын тамгын газраас тайлант онд 643,677.0 мянган төгрөгийн анхны үнэтэй, 395,766.8 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй ашиглах хугацаа нь дуусч байгаа ашиглалтын шаардлага хангахгүй үндсэн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
2.1 Аудит хийсэн 2024 оны санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	178,514,515,347.8	194,716,689,966.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,692,699,558.30	25,978,620,937.70
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,692,699,558.30	25,978,620,937.70
31210	Төгрөг	8,692,699,558.30	25,978,620,937.70
31211	Төрийн сангийн харилцах	8,692,699,558.30	25,978,620,937.70
33	АВЛАГА	1,668,443,860.00	516,260,377.14
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	612,253.14
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	508,443,860.00	353,075,124.00
33500	Бусад авлага	0.00	2,573,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	2,573,000.00
33600	Зээлийн авлага	1,160,000,000.00	160,000,000.00
33620	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	1,160,000,000.00	160,000,000.00
33621	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	1,160,000,000.00	160,000,000.00
34	УРЬДЧИЛГАА	5,754,882.50	2,054,882.50
34600	Урьдчилж гарсан зардал	3,700,000.00	0
34710	Урьдчилгаа тооцоо	2,054,882.50	2,054,882.50
34713	Цалингийн урьдчилгаа	2,054,882.50	2,054,882.50
35	БАРАА МАТЕРИАЛ	116,192,190.00	188,328,912.00
35100	Түүхий эд материал	1,414,915.00	876,203.00
35110	Тусгай зориулалттай материал	1,414,915.00	876,203.00
35400	Хангамжийн материал	114,777,275.00	187,452,709.00
35410	Бичиг хэргийн материал	11,064,870.00	32,505,450.00
35420	Аж ахуйн материал	18,044,215.00	28,052,569.00
35430	Сэлбэг хэрэгсэл	11,254,500.00	11,625,000.00
35440	Түлш, шатах тослох материал	21,325,000.00	2,650,000.00
35450	Барилгын засварын материал	40,644,910.00	40,644,910.00
35460	Хүнсний материал	1,749,700.00	1,749,700.00
35470	Бусад хангамжийн материал	10,694,080.00	70,225,080.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	168,031,424,857.0	168,031,424,857.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	168,031,424,857.0	168,031,424,857.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,884,131,789.81	4,102,424,942.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,884,131,789.81	4,102,424,942.27
39200	Биет хөрөнгө	1,824,456,110.16	2,064,268,235.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,362,977,595.45	1,362,977,595.45
39202	Хуримтлагдсан элэгдэл	-89,208,523.68	-191,194,925.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	620,610,831.88	780,910,831.88
39204	Хуримтлагдсан элэгдэл	-373,453,694.38	-381,407,244.38
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,883,636,149.66	2,362,883,089.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,601,908,703.84	-1,894,663,625.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	132,621,104.25	132,621,104.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	-111,543,149.18	-115,736,340.38
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,780,000.00	19,368,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,055,500.00	-11,490,250.00

Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

39300	Биет бус хөрөнгө	2,059,675,679.65	2,038,156,706.80
39301	Програм хангамж	1,107,864,100.00	1,287,864,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,081,620,405.83	-1,283,139,378.68
39303	Бусад биет бус хөрөнгө	2,033,431,985.48	2,033,431,985.48
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	182,398,647,137.61	198,819,114,908.61
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,361,143,418.30	26,687,464,011.70
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	508,443,860.00	548,843,074.00
41300	Өглөг	508,443,860.00	548,843,074.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	508,443,860.00	508,443,860.00
41360	Бусад өглөг	0	40,399,214.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	40,399,214.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,852,699,558.30	26,138,620,937.70
42200	Урт хугацаат зээл	9,852,699,558.30	26,138,620,937.70
42210	Төгрөг	8,692,699,558.30	25,978,620,937.70
42240	Нөөц /өр төлбөр/ /ТӨҮГ/	8,692,699,558.30	25,978,620,937.70
42220	Гадаад валют	1,160,000,000.00	160,000,000.00
42226	Бусад гадаад эх үүсвэр	1,160,000,000.00	160,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	172,037,503,719.31	172,131,650,896.91
51	Засгийн газрын хувь оролцоо	172,037,503,719.31	172,131,650,896.91
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,868,476,531.69	1,868,476,531.69
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,868,476,531.69	1,868,476,531.69
51200	Хуримтлагдсан үр дүн	169,951,846,444.31	170,045,993,621.91
51210	Өмнөх үеийн үр дүн	169,117,074,631.77	169,756,078,494.31
51220	Тайлант үеийн үр дүн	834,771,812.54	289,915,127.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	217,180,743.31	217,180,743.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	182,398,647,137.61	198,819,114,908.61

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	185,892,341,911.20	340,425,680,080.03
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,125,946,065.20	5,843,630,360.49
120	Нийтлэг татварын бус орлого	4,125,946,065.20	5,843,630,360.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,130,142,413.20	5,542,804,737.08
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,130,142,413.20	5,542,804,737.08
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	993,733,652.00	247,910,223.41
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,070,000.00	52,915,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	181,766,395,846.00	334,582,049,719.54
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	651,600,000.00	3,814,486,952.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	651,600,000.00	3,814,486,952.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,078,326,879.90	2,661,101,300.19

Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,078,326,879.90	2,661,101,300.19
1330	Төсвийн захирагчдаас	180,036,468,966.10	328,106,461,467.35
133003	Хөрөнгийн	180,036,468,966.10	328,106,461,467.35
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,021,101,132.56	12,229,103,485.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,021,101,132.56	12,229,103,485.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,443,626,894.36	8,131,816,120.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,907,710,548.96	2,754,972,932.13
210101	Үндсэн цалин	1,182,050,223.59	1,520,452,426.01
210102	Нэмэгдэл	318,875,820.24	488,575,251.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	202,339,654.93	498,083,175.97
210104	Урамшуулал	204,444,850.20	247,862,078.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,288,608.89	348,335,967.97
210201	Тэтгэврийн даатгал	164,839,944.56	233,405,074.34
210202	Тэтгэмжийн даатгал	19,392,934.49	27,618,446.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,267,947.57	22,694,354.76
210204	Ажилгүйдлийн даатгал	3,779,114.46	12,053,117.41
210205	Эрүүл мэндийн даатгал	38,008,667.81	52,564,974.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,248,149.86	47,675,656.62
210301	Гэрэл, цахилгаан	42,692,056.36	34,774,871.57
210302	Түлш, халаалт	6,234,893.50	5,012,955.05
210304	Байрны түрээс	6,321,200.00	7,887,830.00
2104	Хангамж, бараа материалын зардал	133,760,621.26	167,420,605.10
210401	Бичиг хэрэг	37,825,490.00	65,285,480.00
210402	Тээвэр, шатахуун	80,000,000.00	84,175,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,190,793.19	10,617,979.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,537,938.07	7,342,146.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	206,400.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,724,210.00	60,629,610.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,709,800.00	18,983,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	3,715,600.00
210604	Урсгал засвар	43,014,410.00	37,930,510.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	878,560,624.50	4,485,804,377.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	859,369,345.00	4,456,981,945.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0	3,998,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	10,631,843.00	14,378,243.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	844,446.00	1,410,217.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	286,000.00	367,000.00

Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,579,000.00	2,220,500.00
210807	Газрын төлбөр	2,325,860.00	4,823,870.60
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	524,130.50	1,624,602.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	179,334,130.89	266,976,970.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,453,400.00	4,807,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	540,000.00	1,595,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	173,340,730.89	260,574,970.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,577,474,238.20	4,097,287,364.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,521,825.00	35,224,172.75
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,500,825.00	20,459,172.75
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,021,000.00	14,765,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,530,952,413.20	4,062,063,191.96
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,530,142,413.20	4,062,063,191.96
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	810,000.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	180,871,240,778.64	328,196,576,594.95
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	180,036,468,966.10	327,906,661,467.35
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0	327,906,661,467.35
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	180,036,468,966.10	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	834,771,812.54	289,915,127.60

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/тегрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	178,521,198,366.20	342,785,447,162.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,510,334,107.65	29,430,892,989.68
120	Нийтлэг татварын бус орлого	7,510,334,107.65	29,430,892,989.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,510,334,107.65	29,430,892,989.68
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,130,142,413.20	5,542,804,737.08
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,380,191,694.45	23,888,088,252.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	171,010,864,258.55	313,354,554,172.44
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	651,600,000.00	3,814,486,952.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	651,600,000.00	3,814,486,952.00

Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,078,326,879.90	2,661,101,300.19
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,078,326,879.90	2,661,101,300.19
1330	Төсвийн захирагчдаас	169,280,937,378.65	306,878,965,920.25
133003	Хөрөнгийн	169,280,937,378.65	306,878,965,920.25
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,846,089,393.10	11,987,235,089.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,846,089,393.10	11,987,235,089.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,268,915,154.90	7,889,947,724.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,907,710,548.96	2,757,735,091.90
210101	Үндсэн цалин	1,182,050,223.59	1,523,214,585.78
210102	Нэмэгдэл	318,875,820.24	488,575,251.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	202,339,654.93	498,083,175.97
210104	Урамшуулал	204,444,850.20	247,862,078.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,288,608.89	348,759,061.34
210201	Тэтгэврийн даатгал	164,839,944.56	233,828,167.71
210202	Тэтгэмжийн даатгал	19,392,934.49	27,618,446.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,267,947.57	22,694,354.76
210204	Ажилгүйдлийн даатгал	3,779,114.46	12,053,117.41
210205	Эрүүл мэндийн даатгал	38,008,667.81	52,564,974.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,248,149.86	43,975,656.62
210301	Гэрэл, цахилгаан	42,692,056.36	31,074,871.57
210302	Түлш, халаалт	6,234,893.50	5,012,955.05
210304	Байрны түрээс	6,321,200.00	7,887,830.00
2104	Хангамж, бараа материалын зардал	135,688,923.19	168,145,479.10
210401	Бичиг хэрэг	37,850,130.00	87,017,800.00
210402	Тээвэр, шатахуун	82,665,000.00	65,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,190,793.19	10,617,979.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,983,000.00	5,009,700.00
2105	Нормативт зардал	7,050,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,050,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,038,410.00	76,012,410.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,009,300.00	30,823,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,207,500.00	3,850,600.00
210604	Урсгал засвар	29,821,610.00	41,338,510.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	877,164,614.00	4,488,526,525.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	858,497,465.00	4,456,865,945.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	3,998,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	10,631,843.00	14,378,243.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	844,446.00	1,410,217.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	286,000.00	367,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,579,000.00	5,824,100.00
210807	Газрын төлбөр	2,325,860.00	4,823,870.60
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	859,150.00

Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,725,900.00	6,793,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,185,900.00	5,198,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	540,000.00	1,595,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,577,174,238.20	4,097,287,364.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,221,825.00	35,224,172.75
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,500,825.00	20,459,172.75
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,721,000.00	14,765,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,530,952,413.20	4,062,063,191.96
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,530,142,413.20	4,062,063,191.96
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	810,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	173,675,108,973.10	330,798,212,072.85
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	174,153,650,766.80	313,512,290,693.45
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	174,153,650,766.80	313,512,290,693.45
2200	Дотоод эх үүсвэрээр	174,153,650,766.80	313,512,290,693.45
220001	Барилга байгууламж	133,241,181,155.60	245,762,948,596.00
221001	Их засвар	12,662,317.00	57,596,091,079.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	2,323,432,220.00
223001	Бусад хөрөнгө	40,885,827,394.20	7,598,860,898.45
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,979,900.00	230,957,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-478,541,793.70	17,285,921,379.40
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,171,241,352.00	8,692,699,558.30
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,692,699,558.30	25,978,620,937.70

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,868,476,531.69	217,180,743.31	169,117,074,631.77	171,202,731,906.77
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,868,476,531.69	217,180,743.31	169,117,074,631.77	171,202,731,906.77
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	834,771,812.54	834,771,812.54
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,868,476,531.69	217,180,743.31	169,951,846,444.31	172,037,503,719.31

Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,868,476,531.69	217,180,743.31	169,951,846,444.31	172,037,503,719.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-195,767,950.00	-195,767,950.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,868,476,531.69	217,180,743.31	169,756,078,494.31	171,841,735,769.31
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	289,915,127.60	289,915,127.60
D09	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,868,476,531.69	217,180,743.31	170,045,993,621.91	172,131,650,896.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,012,306,600.0	4,141,842,845.3	870,463,754.69	82.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,012,306,600.00	4,141,842,845.31	870,463,754.69	82.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,966,247,900.00	4,106,618,672.56	859,629,227.44	82.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,440,475,400.00	2,757,735,091.90	682,740,308.10	80.2
210101	Үндсэн цалин	1,873,223,200.00	1,523,214,585.78	350,008,614.22	81.3
210102	Нэмэгдэл	656,010,600.00	488,575,251.38	167,435,348.62	74.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	661,760,000.00	498,083,175.97	163,676,824.03	75.3
210104	Урамшуулал	249,481,600.00	247,862,078.77	1,619,521.23	99.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	430,059,500.00	348,759,061.34	81,300,438.66	81.1
210201	Тэтгэврийн даатгал	292,440,400.00	233,828,167.71	58,612,232.29	80.0
210202	Тэтгэмжийн даатгал	34,404,800.00	27,618,446.88	6,786,353.12	80.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	27,523,800.00	22,694,354.76	4,829,445.24	82.5
210204	Ажилгүйдлийн даатгал	6,881,000.00	12,053,117.41	-5,172,117.41	175.2
210205	Эрүүл мэндийн даатгал	68,809,500.00	52,564,974.58	16,244,525.42	76.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,520,000.00	43,975,656.62	34,544,343.38	56.0
210301	Гэрэл, цахилгаан	51,880,000.00	31,074,871.57	20,805,128.43	59.9
210302	Түлш, халаалт	12,600,000.00	5,012,955.05	7,587,044.95	39.8
210304	Байрны түрээс	14,040,000.00	7,887,830.00	6,152,170.00	56.2
2104	Хангамж, бараа материалын зардал	204,511,400.00	168,145,479.10	36,365,920.90	82.2
210401	Бичиг хэрэг	87,245,400.00	87,017,800.00	227,600.00	99.7
210402	Тээвэр, шатахуун	98,732,000.00	65,500,000.00	33,232,000.00	66.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,524,000.00	10,617,979.10	2,906,020.90	78.5

Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,010,000.00	5,009,700.00	300.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	111,092,800.00	107,170,310.00	3,922,490.00	96.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	65,889,300.00	61,981,200.00	3,908,100.00	94.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,865,000.00	3,850,600.00	14,400.00	99.6
210604	Урсгал засвар	41,338,500.00	41,338,510.00	-10.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	694,753,800.00	674,039,573.60	20,714,226.40	97.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	643,026,800.00	642,378,993.00	647,807.00	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	3,998,000.00	2,000.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	15,150,000.00	14,378,243.00	771,757.00	94.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,500,000.00	1,410,217.00	2,089,783.00	40.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	600,000.00	367,000.00	233,000.00	61.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,059,000.00	5,824,100.00	234,900.00	96.1
210807	Газрын төлбөр	10,468,000.00	4,823,870.60	5,644,129.40	46.1
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,950,000.00	859,150.00	11,090,850.00	7.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,835,000.00	6,793,500.00	41,500.00	99.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,200,000.00	5,198,500.00	1,500.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,635,000.00	1,595,000.00	40,000.00	97.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,058,700.00	35,224,172.75	10,834,527.25	76.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,058,700.00	35,224,172.75	10,834,527.25	76.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,250,900.00	20,459,172.75	10,791,727.25	65.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,807,800.00	14,765,000.00	42,800.00	99.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,012,306,600.00	4,141,842,845.3	870,463,754.69	82.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,412,306,600.00	2,661,101,300.19	751,205,299.81	78.0
320001	Орон нутгийн төсвөөс	3,412,306,600.00	2,661,101,300.19	751,205,299.81	78.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,600,000,000.00	1,480,741,545.12	119,258,454.88	92.5

Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,600,000,000.00	1,480,741,545.12	119,258,454.88	92.5
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	257	257.00	0	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	128	128	0	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	77	77	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	50	50	0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	128	128	0	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	78	78	0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	50	50	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	3,814,486,952.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,814,486,952.00
71105	Авто тээврийн хяналт, зохицуулалт, нийтийн тээвэр	650,000,000.00
80103	Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ	650,000,000.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	650,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	650,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	650,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	650,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	650,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	650,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	650,000,000.00
80316	Цахим шилжилт арга хэмжээ	3,164,486,952.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,164,486,952.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,164,486,952.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,164,486,952.00

Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	3,164,486,952.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,164,486,952.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,164,486,952.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	3,164,486,952.00	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 2,831,087.9 мянган төгрөгийн 5 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Ажилчдаас илүү тооцон суутгасан 392.8 мянган төгрөгийн НДШ-ийг өглөгөөр бүртгээгүй,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн 2,661,101.2 мянган төгрөгийн дүнг буруу илэрхийлсэн,
- Бараа материалын тайланд 1,749.7 мянган төгрөгийн бараа материалыг ангилал буруу илэрхийлсэн,
- Мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогын 161,306.2 мянган төгрөгийг, төвлөрүүлэх шилжүүлэг дээр нэмж илэрхийлсэн,
- Шүүхийн шийдвэрээр ажлаас халагдсан ажилтны цалин, НДШ-д нийт 6,537.9 мянган төгрөгийг төсвөөс төлүүлээд буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж төсвийг хохиролгүй болгох арга хэмжээ аваагүй, балансад авлагаар бүртгээгүй байна.

Эдгээр нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-т *“Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх”* болон санхүүгийн тайлангийн *“тохиолдсон байх”, “толилуулга”* гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 125,047,825.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 5,742.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 124,996,422.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 45,661.3 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 125,047,825.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 124,972,520.9 мянган төгрөгөөр давсан тул *“Хязгаарлалттай”* дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Байгууллагын даргын Б/23 дугаар тушаалаар сахилгын арга хэмжээ ногдуулсан албан хаагчдад 5,742.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д *“Хариуцлагатай байх”*, 6 дугаар зүйлийн 6.4.1-т *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол *“Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”*-ын 2 дугаар зүйлийн 2.1-т *“Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно”* гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналийн *“тохиолдсон байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг бодитоор үнэлээгүй, ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн албан хаагчдад урамшуулал олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан 5,742.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1.Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 124,956,022.8 мянган төгрөгийн 88 төсөл арга хэмжээг захиалагч байгуулагад хүлээлгэн өгөх хүртэл бусад эргэлтийн хөрөнгөд бүртгээгүй, хөрөнгийн зардлаар шууд бүртгэсэнг завсрын аудитаар залруулах зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын 5.4.4-т “Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана”, 5.4.5-д “Захиалагч байгууллага нь их засварын ажлын зардлыг засварын ажлыг хүлээлгэн өгсөн актыг үндэслэн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь Төсөл арга хэмжээний зардлыг бусад эргэлтийн хөрөнгөд бүртгээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2.Төрийн албан хаагчийн буруутай үйлдлээс үүссэн 40,399.2 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулж ажиллаагүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, 103.2 “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”, 103.3-д “Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчдын буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй өр төлбөрийг төсвөөс төлүүлсэн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг буруу тооцоолж 3,185.3 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг тухай бүр үнэн зөв тооцоолох, төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй ажиллах,

2.Эд хөрөнгийн тооллогыг хангалттай гүйцэтгээгүй , ажилчдын хэрэгцээнд ашиглаж байгаа эдэлгээний хугацаа дууссан 27,938.0 мянган төгрөгийн нормын хувцас, хэрэглэл балансад бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилчдын хэрэгцээнд ашиглаж байгаа, нормын хувцсыг эдэлгээний хугацаа дуусахад балансаас хасч байх, эд хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэх,

3.Үнэлгээний хорооны гишүүдэд ажилласан цаг, оролцсон тендерийн тоо зэрэг нотлох баримтын бүрдэлгүй 14,538.0 мянган төгрөгийг урамшууллыг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаал Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам-ын 3.7-д ""Захиалагч өөрийн ажилтан, албан хаагч бус мэргэшсэн ажилтныг үнэлгээний хорооны гишүүнээр ажиллуулсан бол үнэлгээний хорооны хуралд оролцсон цаг тутамд Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн дараах хэмжээний урамшууллыг тооцон өөрийн төсөвт багтаан олгоно, 3.7.1-д "харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас бага төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтын хувьд цаг тутамд ТЗ-7 албан тушаалын зэрэглэлийн нэг цагийн цалинтай тэнцэх", 3.7.2-т "харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтын хувьд цаг тутамд ТЗ-6 албан тушаалын зэрэглэлийн нэг цагийн цалинтай тэнцэх"" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Урамшуулал олгохдоо нотлох баримт, тооцооллыг үндэслэлтэй хийх, ажлын гүйцэтгэлд үндэслэн урамшуулал олгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажилчдаас илүү тооцон суутгасан НДШ-ийг өглөгөөр бүртгээгүй.	1	392.8			1	392.8	1	392.8				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтийн дүнг буруу илэрхийлсэн	1	2,661,101.3			1	2,661,101.3	1	2,661,101.3				
Бараа материалын ангилал буруу бүртгэсэн	1	1,749.7			1	1,749.7	1	1,749.7				
Үр дүнгийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлэх шилжүүлэгт нэмж илэрхийлсэн.	1	161,306.2			1	161,306.2	1	161,306.2				
Шүүхийн шийдвэрээр ажлаас халагдсан ажилтны цалин, НДШ-ийг төсвөөс төлүүлээд авлагаар бүртгээгүй.	1	6,537.9			1	6,537.9	1	6,537.9				
Дүн	5	2,831,087.9			5	2,831,087.9	5	2,831,087.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТАХ-ийн буруутай үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн өглөгийг барагдуулж ажиллаагүй	1	40,399.2			1	40,399.2						
Цалин, НДШ-ийн буруу тооцооллоос үүдэн цалинтай холбоотой авлага үүсгэсэн	1	3,185.3					1	3,185.3				
Тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан ажилтнуудад улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон.	1	5,742.0	1	5,742.0								
Эд хөрөнгийн тооллого хангалттай гүйцэтгээгүй, ажилчдын хэрэгцээнд ашиглаж, эдэлгээний хугацаа дууссан нормын хувцас, хэрэглэл балансад бүртгэлтэй байна.	1	27,938.0					1	27,938.0				
Үнэлгээний хорооны гишүүдэд урамшууллыг олгохдоо ажилласан цаг, оролцсон тендерийн тоо зэргийг нотолсон баримт хангалтгүй, тооцоолол байхгүй.	1	14,538.0					1	14,538.0				
Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 88 төсөл арга хэмжээг захиалагч байгуулагад хүлээлгэн өгөх хүртэл	1	124,956,022.8			1	124,956,022.8	1	0				

бусад эргэлтийн хөрөнгөд бүртгээгүй, хөрөнгийн зардлаар шууд бүртгэсэн												
Дүн	6	125,047,825.3	1	5,742.0	2	124,9996,422.0	3	45,661.3	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой								
Тайлант онд холбогдох хууль тогтоомжийн дагуу цахим худалдан авалт хийгээгүй.	1	125,696.2					1	125,696.2
Дүн	1	125,696.2	-	-	0	0	1	125,696.2



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 03 дугаар сарын 14

№ 96/А0224309

Улаанбаатар хот

НТАГ - 2025/03/14 - СМ - ТМ/3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд байгууллагын даргын Б/23 дугаар тушаалаар сахилгын арга хэмжээ ногдуулсан албан хаагчдад 5,742,000.00 (таван сая долоон зуун дөчин хоёр мянган) төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан;" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1.Нийслэлийн замын хөгжлийн газар албан хаагчдын ажлын үр дүнг бодитоор үнэлээгүй, ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн албан хаагчдад урамшуулал олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан 5,742,000.00 (таван сая долоон зуун дөчин хоёр мянган) төгрөгийн Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар¹-т ирүүлэхийг Нийслэлийн замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр, нягтлан бодогч Б.Хонгорзул нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН¹:

АУДИТОР

ХЯНАСАН:

Л.ОДОНТУЯА

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1405050126



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 334/А 0271309

Улаанбаатар хот

НТАГ - 2025/053/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн албан хаагчийн буруутай үйлдлээс үүссэн 40,399,214.00 (дөчин сая гурван зуун ерэн есөн мянга хоёр зуун арван дөрөв) төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулна гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", 103.2 "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", 103.3 "Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-т "төсвийг зориулалт бусаар зарцуулсан"; заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Төрийн албан хаагчдын буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй өр төлбөрийг төсвөөс төлүүлсэн зөрчлийг зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга дарга Б.Одбаяр, нягтлан бодогч Б.Хонгорзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

АУДИТОР

Л.ОДОНТУЯА

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

ХЯНАСАН:

Д.ОТГОНБАЯР

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1425040316



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 333/А0271309

Улаанбаатар хот

НТАГ - 2025/053/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Замын хөгжлийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 124,956,022.8 мянган төгрөгийн 88 төсөл арга хэмжээг захиалагч байгууллагад хүлээлгэн өгөх хүртэл бусад эргэлтийн хөрөнгөд бүртгээгүй, хөрөнгийн зардлаар шууд бүртгэснийг завсрын аудитаар залруулах зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын 5.4.4-т "Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана", 5.4.5-д "Захиалагч байгууллага нь их засварын ажлын зардлыг засварын ажлыг хүлээлгэн өгсөн актыг үндэслэн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй," заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Төсөл арга хэмжээний зардлыг бусад эргэлтийн хөрөнгөд бүртгээгүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга дарга Б.Одбаяр, нягтлан бодогч Б.Хонгорзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Л.ОДОНТУЯА

ХЯНАСАН:

САНХҮҮ НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР



1 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1425040314